

Биндэр сумын танилцуулга

1923 онд Ардын засгийн газрын 38, 43-р тогтоол, 1923.01.05-ны өдөр батлагдсан нутгийн захиргааны дүрмийн дагуу Хан Хэнтий уулын аймгийн Биндэръяа уулын хошуу хэмээн нэрлэж Баянхутаг, Баян-Өлзийт, Баруун баян, Хутагтхайрхан, Дэлгэрхаан Жинс, БИНдэръяа, Түмэн, Жаргалан, Баря, Баян-Адрага зэрэг 10 сумаар зохион байгуулж төв Биндэръяа нь Хурх голын хойно төвлөрч Шагдарын Гомбо гэдэг хүн хошуу даргаар ажиллаж байжээ. Хэнтий аймгийн Биндэр сум нь Хамаг Монголын Ханлиг-Чингис хааны голомт, Их Монгол улсын Тулгар төрийн тоонот нутаг хэмээн түүхийн сурвалж бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тэмдэглэгдсээр ирсэн газар билээ. Анх 1980-аад оны үед бие даасан засаг захиргааны нэгж болон Халхын Сэцэн Хан аймгийн Хөвчийн Жонон вангийн хошуу гэж бүрэлдэн тогтсон гэж үздэг. Тэр үедээ уг хошуу нь Онон, Хурх, Эг, Барх, Угалзар Тэнгилэг, Уужим, Жавхлант, Урт Гурван Манхаадай зэрэг уудам нутгийг хамарч, Сэцэн Хан аймгийн 25 хошууны 16-тай нь хил залган, хүн амынхаа тоогоор аймагтай томоохонд тооцогдож байжээ.

Олноо өргөгдсөн Монгол улсын 12 дугаар оны өвлийн эхэн сарын 27-ны өдөр буюу 1923 онд Ардын нам засгийн газраас тус сумыг Хан Хэнтий уул аймгийн шадар сайд Эрдэнэ дайчин Жонон засаг дарга, хошой Чин Ван Цогбадрахын хошуу хэмээн нэрийдэж байв. Мөн ондоо Ардын Засгийн газраас гаргасан тогтоолууд, нутгийн захиргааны дүрмийн дагуу аймаг хошуу, нутгийн захиргааг шинэчлэн Хөвчийн Жонон вангийг хошууг Хан Хэнтий уулын аймгийн Биндэръяах Хан уулын хошуу хэмээн нэрлэж хошууны төвийг Онон Хурхын бэлчирт төвлөрүүлсэн ажээ.

Эдүгээ манай сум 536,6 мянган га газар нутагтай, Монгол улсын хилийн хойд хэсэгт Хэнтийн нурууны зүүн салбар уулсын өвөр, ойт хээрийн бүсийн үзэсгэлэнт сайхан байгаль бүхий өргөн уудам нутгийг хамарч ОХУ – ын Байгаль чанадын хязгаар, Дадал, Баян-Адрага, Батноров, Хэрлэн, Өмнөдэлгэр, Батширээт сумдуудтай хил залган орших бөгөөд Өндөрхаан хотоос 180 км, Улаанбаатар хотоос 406 км алслагдсан, Хэнтий аймгийн хойд бүсийн тулгуур төв 4000 гаруй хүн амтай томоохон сум юм.

Онон голынхоо хойд тал сумын баруун хойд талын ой мод ихтэй хэсгээр буриад үндэстэн голдуу оршин суудаг. Тал хээр хосолсон цагаандуу бэлчээр сайтай, сумын зүүн, зүүн урд, урд, баруун талаар голчлон халх үндэстэн амьдардаг. Халх, Буриад үндэстний аж байдлыг нэг дороос харьцуулан харах боломжтой газар юм. Сэцэн хан аймгийн Хөвчийн дайчин жонон ван Цогбадрахын хошууг 1923 онд шинэ засаг төрийн бодлогоор сольж уул усны нэрээр нэрлэх болоход энэ нутаг орныхон хошууныхаа гол шүтээн, овоо хүний нийгмийн бичиг соёл ёс заншлын бүхий л түүхийг агуулсан Рашаан хад МНТ номонд Бидэр хошуу буюу Биндэръяа хан уулынхаа нэрээр нэрлэжээ. Биндэръяа хан уулын хошуу дотроо 150 өрх тутам сум хэмээх засаг захиргааны нэгжийг бий болгосон байна. Үүнд Биндэръяа, Дунд баян, Баян

адрага, Сүмбэдовдон, Барч, Хэнтий, Баян өлзийт, Жинст, Дэлгэрхаан, Түмэнжаргалант гэх мэтээр нэрлэж ирсэнээс уг сумдыг 1931 онд нэгтгэн томруулахад уугуул нэрээ одоогийн байдлаар авч үлдсэн сум бол Биндэр, Баян адрага сумд юм

1953 онд засгийн газрын тогтоолоор Биндэр сумын баруун хойд талын багуудаар Батширээт сумыг байгуулснаар Биндэр сумын уугуул нэр болох Биндэрьяа хан уулын овоо, тэр орчмын газар нутаг Батширээт сумын Хурх багийн нутагт хамаарах болжээ. Сонирхолтой нь Биндэрийн овоог Батширээт суманд шилжүүлсний хойтон жил буюу 1954 оны зун Зуухын баянголыг уруудан Биндэрийн овооны зүүн талын цэлгэр хөндийг дүүртэл үерийн ус дэлхэн бууж улмаар Хурх голыг уруудан хоёр талынхаа ууланд тулсан үерийн ус Хурх голын адагт байсан Биндэр сумын төвийг авч урсган алдав. Үүнээс Биндэр сумын төв нүүж одоогийн байгаа газарт буух нэг гол шалтгаан болжээ.

3. сумын брэнд

Биндэрчүүд хэдийнээсээ хөдөлмөрч ард түмэн. Тэр ч утгаараа үйлдвэрлэл их явуулж гарсан бүтээгдэхүүнээр нь нилээдгүй танил болсон байдаг. Биндэрийн талх, цөцгий, тойлтой тос, сүү цагаан идээ бол улсдаа алдартай. Түүний хажуугаар сумын брэнд бүтээгдэхүүнд шинээр хүч түрэн орж ирж байгаа бүтээгдэхүүн бол Зөгийн бал юм. Балаа Биндэрчүүд гачуурт ХХК нийлүүлэхээс гадна үзэсгэлэн худалдаагаар борлуулж байна. Жилдээ нийт 387-402 бүл зөгийн





4. малын тоо

Бүгд	195271
Адуу	14313
Үхэр	28577
Тэмээ	161
Хонь	83474
Ямаа	68746

5. амьтан ургамал

Биндэр сумын нутаг дэвсгэрт 90 овог, 321 төрөлд хамаарах 958 зүйл ургамал тохиолдож байгааг тогтоосон. Тухайн бүс нутгийн ургамлын аймгийг бүрдүүлж буй зонхилогч овогос гол гэсэртэн (*Asteriaceae*), үетэн (*Poaceae*), буурцагтан (*Fabaceae*), өлөнтөн (*Superaceae*), төрлөөс шарилж (*Artemisia*), улалж (*Carex*), сонгино (*Allium*), гичгэнэ (*Potentilla*), бургас (*Salix*) байна.

Тусрайонд 23 овог 47 төрөлд хамаарах 57 зүйл ховор, 10 овог, 12 төрөлд хамаарах 16 зүйл нэн ховор ургамал тэмдэглэгдсэн. ОББЦГ-ын ургамлын жагсаалтаас харахад 25 овог, 43 төрөл 53 зүйл хүнсний, 49 овог, 139 төрөл, 241 зүйл эмийн, 47 овог, 174 төрөл, 400 зүйл бэлчээрийн ургамал ургаж байна. Монгол Улсын улаан номонд орсон ховор зүйлүүдээс дагуур шинэс (*Larix dahurica*), дагуур сараана (*Lilium dahuricum*), цагаан цээнэ (*Paeonia lactiflora*), дагуур тэрэлж (*Rhododendron dahuricum*), эмийн бамбай (*Valeriana officinalis*), толбот саадганцэцэг (*Cypripedium guttatum*) зэрэг зүйлүүдийг нэрлэж болно. Монгол улсын Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын жагсаалтад орсон манж гандигар (*Sambucus manshurica*), томнавчит дэгд (*Gentiana mac-gophylla*), эгэл годил-өвс (*Acorus calamus*), өргөн зуншилцэцэг (*Majanthemum dilatatum*), цайвардуу могойн-идээ

(*Sedum pallescens*), намхан мухарцагаан(*Polygonatum humile*), тойруулгат чандганчих(*Paris verticillata*), цагаан цээнэ(*Paeonia anomala*), жижиг навчит яшил(*Rhamnus parvifolia*), уссур яшил(*Rhamnus ussuriensis*), буржгар сараана(*Lilium martagon*), дагуур тэрэлж(*Rhododendron dahuricum*), нүцгэн товьцэцэг(*Mitella nuda*), ховор ургамлаас ацан ажигана(*Stellaria dichotoma*), норвеги гичгэнэ(*Potentilla norvegica*), эмийн бамбай (*Valeriana officinalis*), гурвалжин ихзул(*Synurus deltoides*), шоргор

Уул толгодын орой, энгэр, баруун, зүүн хажуугаараа хад асга, нураг чулуу ихтэй ба уул толгодын хормойгоор шим тэжээл сайтай, ус сайн шингээж нэвтрүүлдэг хөрстэй. Харин Балж голын дагуу хэсэг хэсэг газраараа элсэн хурдас нилээд дайралддаг [6].

Энэ бүс нутаг нь Монгол орны сибирь шинэс(*Larix sibirica*)-ний зүүн тархац, дэлхийн дагуур шинэс(*Larix dahurica*)-ний өмнөд тархац бөгөөд Крыловын нарс(*Pinus Krylovii*), дагуур шинэс, Чекановскийн шинэс(*Larix czekanowski Bogdanov* (1931)) гэсэн гурван зүйлийн шилмүүст мод Монгол орныхэмжээнд зөвхөн энэ газарт тархсан байна. Эдгээрээс Монгол улсын “Улаан ном”-д дагуур шинэс орсон. Энд сүүлийн жилүүдэд хэд хэдэн удаагийн түймэр гарсанаас болж шинэсэн ой хусан ойгоор солигдох явц үргэлжилсээр байна. Ийм хоёрдогч гаралтай хусан ойн дотор 40-60 насны хус зонхилж байна

1.4.2.2 Амьтны аймаг Хөхтөн: Биндэр сум нь хөхтөн амьтны оршин амьдрах таатай нөхцөл бүрдсэн манай орны онцлог газруудын нэг бөгөөд энд 6 багт хамаарах 54 зүйл хөхтөн амьтад суурин болон гүйдлийн байдлаар амьдардаг. Эдгээрээс тус цогцолборт газрын хэмжээнд 15 зүйл “элбэг”, 29 зүйл “хэвийн”, 10 зүйл “ховор” тохиолддоогоос 5 зүйл (хүрэн баавгай (*Ursus arctos*), баданга хүдэр (*Moschus moschifer-us*), саарал чоно(*Canis lupus*), шилүүс мий(*Lynx lynx*), мануул мий(*Otocolobus manul*)), Монгол улсын улаан номонд 4 зүйл (баданга хүдэр, молцог хандгай (*Alces alces*), дагуур зараа(*Erinaceus dauricus*), голын халиу(*Lutra lutra*)), Олон улсын улаан номонд 2 зүйл (саарал чоно, нохой элбэнх(*Nyctereutes procyonoides*)), Монгол орны ховор амьтны жагсаалтад 3 зүйл (халиун буга(*Cervus elaphus*), молцог хандгай, хүрэн баавгай) орсон байна. Тус газрын томоохон хөхтөн амьтдын хувьд Монгол орны бусад нутгийн нэгэн адил тоо толгой, тархац нутаг нь эрс багасч байна. ШУА-ийн Биологийн хүрээлэн, БОАЖЯ-аас 2010 онд хийсэн ойн тууртны нөөцийн үнэлгээний судалгаагаар боргөрөөс 1769 км, халиун буга 1490 км², зэрлэг гахай 1753 км², баданга хүдэр 80 км², молцог хандгай 97 км² талбайд тархаж байгаа

Мөн тус газарт сүүлийн жилүүдэд нүүдэллэн ирсэн усны булга(Mustela vision)Онон, Балж, Хөмөл голын орчимд нилээдгүй олширч байгаа дүн мэдээ байдаг. Сүүлийн жилүүдэд сумын нутагт цагаан зээр(Procavia gut-turosa)ирж өвөлжиж байна.

Шувуу:

Биндэр суманд 18 багийн 44 овгийн 126 төрлийн 223 зүйл шувуу бүртгэгдэснээс орших хэлбэрийн хувьд 51 зүйл суурин амьдралтай, 172 зүйл нүүдлийн шувууд байна. Нүүдлийн шувуудын 134 зүйл нь өндөглөдөг, 20 зүйл дайрч өнгөрдөг, 7 зүйл өвөлждөг, 1 зүйл тохиолдлын байдлаар хааяа тааралддаг.

6. түүхийн дурсгалт газар

6.1 Дэлүүн болдог

Онон хурхын бэлчирт байрлах Дэлүүн болдог

Эзэн Чингис хааны төрсөн газар. Түүхийн олон олон /МНТ, Хөх судар/ г.м эх сурвалжуудад тогтоц байршилаар нь зааж өгсөн байдаг. Сүүлийн жилүүдэд эрдэмтэд, аялагчид ихээр ирж үзэж танилцаж байна

6.2 Их хуралдай

Монголын Их Эзэнт гүрэн байгуулагдсан түүхэн газар. 1206 онд Их хуралдайг зарлаж хамаг Монголын хошуу ноёд зуглан Тэмүүжинг их хаанд өргөмжилсөн. 2018-2019 оны улсын төсөв 2- тэрбум төгрөгийг төсөвт суулгаж томоохон бүс нутгийн цогцолбор барихаар ажиллаж байна.

булш, хэрэгсүүр

Хүннүгийн үе, түрэгийн үеийн булшууд элбэг байх бөгөөд тэмдэглэл хийж түүхэн тайлбаруудыг нь хийж эхлээд байна

6.4 Онон, Хурх

МНТ болон бусад түүхийн эх сурвалжуудад олноор нэр нь дурьдагдах гол мөрөн сумын төвийн зүүн болон урд талаар урсан байна. Нутгийн зон олон рашаан хэмээн хүндэтгэн үздэг.

7. байглийн баялаг орд газар

Биндэр сум ашиглалтын 1 эрхтэй талбайтай бөгөөд сумын хөгжлийн төлөвлөгөөнд уул уурхайгүй ногоон сум, ногоон хөгжлийг эрхэмлэж алсын хараа, эрхэм зорилгодоо тусгасан байдаг.

Нутгийн иргэд самар, жимс, ногоо түүж, тарьж хэрэгцээгээ ханган борлуултанд боловсруулж нийлүүлдэг бөгөөд орлогын нэг томоохон эх үүсвэр билээ.

8. Жижиг дунд үйлдвэрлэл

Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех 4 байгаа бөгөөд зун, намрын 5 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулдаг. Мөн модоор байшин, палк, банз хийдэг мөн 4 ААН нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Талх нарийн боовны 7 хувь хүн үйл ажиллагаа явуулж, сум, тойргийн сумдынхаа зах зээлд хүрч ажиллаж байна.

9. хөгжлийн төлөвлөгөө

Биндэр сум тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо Хөдөө аж ахуй, Аялал жуулчлал гэсэн байдаг. Түүнчлэн сүү, махны үйлдвэр, аялал жуулчлалын томоохон цогцолборууд барих нь иргэдийн орлого, сумын хөгжилд макро түвшиний нөлөөлөл үзүүлэх боломжтой. 2014-2030 оны хөгжлийн төлөвлөгөөний товхимол.